

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган мээж ОНӨХХК-ий 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/02/НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он	Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 7034-2580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Г.Цэрэнлхам Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlkhamg@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	7
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
4.1 Байгууллагын үйл ажилагаа.....	8
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	8
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
8. Аудитын илрүүлэлт	12
8.1 Залруулсан алдаа	12
8.2 Төлбөрийн акт.....	12
8.3 Албан шаардлага	13
8.4 Зөвлөмж	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУ	Монгол улсын
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
БМ	Бараа материал
БУА	Булган аймаг

1.Аудитын санал дүгнэлт


**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.03.15 № 256
танай _____ ны № _____ т

БУЛГАН МЭЭЖ ОНӨХХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ОДХҮҮ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Булган мээж ОНӨХХК-ий 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Булган мээж ОНӨХХК-ий 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр Булган аймгийн төвд баригдсан 3000 м3/хоногийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламж барьж байгуулсан "Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл"-ийн зээлийн төлбөр 6,696.6 тэрбум төгрөгийг 2025-2038 оныг дуустал тус тус төлөх хуваарьтай байна. Компаний санхүүгийн чадавхтай уялдуулан урт хугацаат өр төлбөрийг эргэн төлөх гэрээг Булган аймгийн ЗДТГ-тай байгуулаагүй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

D:/bichighereg/2022A4foot

006020319

Булган мээж ОНӨХХК нь аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж ажиллаагүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4100t

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	137,975,335.68	162,233,035.14
1.1.02	Дансны авлага	97,850,353.60	706,782,219.61
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	96,979,877.21	130,563,908.58
1.1.04	Бусад авлага	13,424,398.76	6,991,607.28
1.1.06	Бараа материал	7,036,808,328.64	7,036,397,430.83
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	39,000,000.00	42,348,935.36
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	7,422,038,293.89	8,085,317,136.80
1.2.01	Үндсэн хөрөнгө	6,459,787,175.73	11,142,513,397.22
1.2.02	Биет бус хөрөнгө	9,000,000.00	6,000,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,468,787,175.73	11,148,513,397.22
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,890,825,469.62	19,233,830,534.02
2.1.1.01	Дансны өглөг	809,058,823.87	2,731,048,164.12
2.1.1.03	Татварын өр	9,829,795.25	3,054,708.54
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	6,173,291.46	8,382,562.41
2.1.1.09	Нөөц /өр төлбөр/	3,428,650.00	4,813,157.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	790,053.01
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	828,490,560.58	2,748,088,645.08
2.1.2.01	Урт хугацаат зээл	10,219,647,991.55	10,219,647,991.55
2.1.2.02	Нөөц /Өр төлбөр/	136,309.09	136,309.09
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	10,219,784,300.64	10,219,784,300.64
2.2	Өр төлбөрийн нийт дүн	11,048,274,861.22	12,967,872,945.72
2.3.01	Өмч: -төрийн	4,061,049,869.67	9,290,694,877.55
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	381,177,427.96	381,177,427.96
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(1,599,676,689.23)	(3,405,914,717.21)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(1,806,238,027.98)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(1,599,676,689.23)	(1,599,676,689.23)
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,842,550,608.40	6,265,957,588.30
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	13,890,825,469.62	19,233,830,534.02

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,085,565,855.93	4,660,639,332.31
2	Борлуулатын өртөг	5,555,399,307.44	6,069,150,592.63
3	Нийт ашиг (алдагдал)	(1,469,833,451.51)	(1,408,511,260.32)
4	Түрээсийн орлого	6,000,000.00	6,335,908.00
5	Хүүний орлого	10,571,568.42	1,307,831.58
8	Бусад орлого	260,102,462.33	354,504,283.79
8.01	Орлогын дүн	276,674,030.75	362,148,023.37
10	Ерөнхий ба удирдлагын зардал	356,749,593.71	356,716,308.47
12.1	Зардлын дүн	356,749,593.71	356,716,308.47
17	Бусад ашиг (алдагдал)	(144,088,245.99)	(403,158,482.56)

17.1	Олз, гарзын дүн	(144,088,245.99)	(403,158,482.56)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,693,997,260.46)	(1,806,238,027.98)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,693,997,260.46)	(1,806,238,027.98)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,693,997,260.46)	(1,806,238,027.98)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/					
Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,560,913,641.37	381,177,427.96	2,500,136,228.30	(1,599,676,689.23)	2,842,550,608.40
Өмчид гарсан өөрчлөлт			5,229,645,007.88		5,229,645,007.88
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал				(1,806,238,027.98)	(1,806,238,027.98)
2021 оны 12 дугаар сарын 31-ны үлдэгдэл	1,560,913,641.37	381,177,427.96	7,729,781,236.18	(3,405,914,717.21)	6,265,957,588.30

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,671,809,182.04	5,053,813,557.36
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,375,108,174.42	4,570,463,585.67
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	59,745,935.10
1.1.6	Бусад мөнгөн орлого	296,701,007.62	423,604,036.59
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,009,277,076.29	4,969,782,752.34
1.2.1	Ажиллагчдад төлсөн	694,629,376.50	686,061,363.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	242,334,828.78	239,821,370.15
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	858,438,944.85	526,346,337.32
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	2,503,495,096.08	2,731,708,550.34
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	98,386,272.72	157,316,980.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	425,188,667.61	179,686,648.14
1.2.9	Бусад мөнгөн зарлага	186,803,889.75	448,841,503.39
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(337,467,894.25)	84,030,805.02
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	115,127,200.00	59,793,181.82
2.2.1	Хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	115,127,200.00	59,793,181.82
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн дүн	(115,127,200.00)	(59,793,181.82)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	387,184.04	20,076.26

3.1.4	Бусад	387,184.04	20,076.26
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	28,587.81	-
3.2.5	Бусад	28,587.81	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	358,596.23	20,076.26
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(452,236,498.02)	24,257,699.46
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	590,211,833.70	137,975,335.68
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	137,975,335.68	162,233,035.14

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Шугам хоолойн цэвэр ус	м3	86,230.00	88,255.40	108,233.52	(19,978.12)	122.64
2	Бохир ус татан зайлуулах	м3	68,240.21	67,512.40	85,653.23	(18,140.83)	126.87
3	Тээврийн цэвэр ус	м3	15,994.00	16,149.00	19,862.00	(3,713.00)	122.99
4	Түгээсэн дулаан	гкал	32,220.00	32,746.65	33,322.00	(575.35)	101.76

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган мээж ОНӨХХК-ий 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, компаний засаглал, найдваргүй авлага, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 05-аас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган мээж ОНӨХХК-ий 2021 оны санхүүгийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/50 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн. Энэ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж ажиллаагүй, хэрэглэгчтэй байгуулсан гэрээг нь учир дутагдалтай, дотоод хяналт шалгалт хийгээгүй зэргээс шалтгаалсан байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч тус

байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан, хууль эрх зүйн орчинтой уялдуулан шинэчлэх шаардлагатай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Булган мээж ОНӨХХК-ий 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлогоос сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлогын 4,671,809.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 467,718.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Булган мээж ОНӨХХК-ий зорилго нь Иргэд байгууллагын эрх ашгийг эрхэмлэн хүндэлж, эрүүл ахуйн шаардлагад хангасан цэвэр ус түгээн нийлүүлж, хэрэглэгчдийг найдвартай дулааны эрчим хүчээр ханган ажиллахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ,
2. Дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах,
3. Барилга угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил, ус хангамж, ариутгах татуургын болон дулааны магистраль шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт, цахилгаан хангамжийн болон бусад шугам сүлжээний угсралтын ажил.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Булган мээж ОНӨХХК-ийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 06 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3ж дугаар зүйлд “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар тогтоолоор томилж байгаа нь МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Компаний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцэж байна.

Гүйцэтгэх удирдлагыг аймгийн Засаг даргын 2020 оны Б/85 тоот захирамжаар томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2 дахь заалттай нийцэж байна.

Булган мээж ОНӨХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн 7 гишүүдийн цалин, урамшууллыг улирлын 1,800.0 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “... цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд хийж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталж ажиллаагүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3 “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг ТУЗ-ийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 3-аар бууруулан 75 орон тоотойгоор баталж, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан 1,068.6 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	137,975.34	162,233.04	24,257.70
Авлага	208,254.63	844,337.74	636,083.11
Бараа материал	7,075,808.33	7,078,746.37	2,938.04
Үндсэн хөрөнгө	6,468,787.18	11,148,513.40	4,679,726.22
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,890,825.47	19,233,830.53	5,343,005.06
Богино хугацаат өглөг	828,490.56	2,748,088.65	1,919,598.08
Урт хугацаат өглөг	10,219,647.99	10,219,647.99	-
Эздийн өмч	2,842,550.61	6,265,957.59	3,423,406.98
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	13,890,825.47	19,233,830.53	5,343,005.06

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 41.3 мянган төгрөг болж, 896.2 мянган төгрөгийн буурсан нь бэлэн мөнгөний зарцуулалтыг багасгасан байна.

Банк дахь харилцах дансанд 162,233.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас Хаан банкны хоёр харилцах дансанд 63,874.5 мянган төгрөг, Төрийн банкны харилцах дансанд 3,258.8 мянган төгрөг, Төрийн банкны хугацаатай хадгаламж 94,866.2 мянган төгрөг, Хас банкны харилцах дансанд 191.7 мянган төгрөг тус тус байна.

Авлагын үлдэгдэлд дулааны авлага 639.5 мянган төгрөг, дулаан болон цэвэр усны орон сууц айл өрхийн авлага 67.4 мянган төгрөг, НӨАТ-ын авлага 130.5 мянган төгрөг, бусад авлага 6.9 мянган төгрөгийг эзэлж байна.

Тайлант онд “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуй нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2020 оны 211, Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 91 дүгээр тогтоолоор тус тус айл өрхийн болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээний хүрээнд үүссэн төрөөс авах авлага 217.6 мянган төгрөгөөр, Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2021 оны 459 дүгээр Булган аймгийн Булган сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф нэмэгдэж 465.8 мянган төгрөгийн авлагын өсөлтөд тус тус голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 844.3 мянган төгрөгийн авлага байна. Найдваргүй авлагыг хасагдуулга аргаар тооцдог байна. Тайлант онд найдваргүй авлагын нөөц байгуулаагүй, ТУЗ-ийн 2021 оны 11 дүгээр тогтоолоор 115.5 мянган төгрөгийн найдваргүй авлагыг данснаас хассан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 7,078,746.4 мянган төгрөг болж, 2,938.0 мянган төгрөгөөр өссөн нь ажлын хувцас, шатахуун, бичиг хэргийн материал нөөцөлснөөс шалтгаалжээ. Тайлант онд худалдан авалтаар 445,766.3 мянган төгрөгийг шууд гэрээгээр бэлтгэсэн байна.

Бараа материалын дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэлд Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд Булган аймгийн төвд баригдсан 3000 м3/хоногийн хүчин чадалтай 6,696.6 сая төгрөгийн цэвэрлэх байгууламжийн барилга бүртгэж, 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар аудитлагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй 42,348.9 мянган төгрөгийн борлуулах зорилгоор эзэмшиж байгаа бараа материал байна. Энэ нь 2016-2017 онд үүссэн хаалтын өрөнд Их Азар ХХК-иас авсан 14,000.0 мянган төгрөгийн 2 ширхэг гарааш, дулааны цахилгаан станц ашиглалтад орсноор ашиглах боломжгүй болсон 32,000.0 мянган төгрөгийн зуухны яндан, зуухны тогоо байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Хөрөнгө бэлтгэх тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 38 дугаар тогтоол, ТУЗ-ийн 07 дугаар тогтоолоор шинээр ашиглалтад орох цэвэрлэх байгууламжийн конторын өрөө тасалгаанд шаардлагатай тавилга эд хогшил, тоног төхөөрөмж 13,330.0 мянган төгрөгөөр, 12 усан санд ухаалаг уст цэгт автоматжуулалтын тоног төхөөрөмж тус тус худалдан авсан,
- Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 96 тоот албан бичиг, аймгийн ИТХ-ын Хуралдааны 2021 оны 05/08 дугаар тогтоолыг үндэслэн 10 нэр төрлийн 5,229,645.0 мянган төгрөгийн шугам хоолойг үнэ төлбөргүй шилжүүлэн авснаас тус тус нэмэгдсэн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 2,748,088.6 мянган төгрөгийн өр төлбөр байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 10,219,784.3 мянган төгрөгийн байгаа нь Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Хот байгуулалтын салбарын “МОН-2301 төсөл”-ийн дамжуулан зээлдэх гэрээний 3,522,742.9 мянган төгрөгийг 2014-2036 оныг дуустал 22 жилд, “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл” дамжуулан зээлдэх гэрээний 6,696,905.1 мянган төгрөгийг 2025-2038 он дуустал 13 жилд төлөх хуваарьтай холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөрийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байгаа нь Сангийн яам зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсан, барилга байгууламжийн ашиглалтыг жигдрүүлэхээс шалтгаалсан, УХӨТ буурахгүй байх үр дагавартай байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт жинхэнэ хэрэгжилтийн зарчимд бүртгэлээ хөтлөн, тэдгээрийг мөнгөөр төлөгдсөн эсэхээс үл хамааран зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг үйл явдал, ажил гүйлгээ хийгдсэн тухайн тайлангийн хугацаанд хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг өмнөх онтой харьцуулахад 513,751.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2014 онд хийгдсэн хуучин шугам хоолойн үндсэн хөрөнгөд бүртгэж, элэгдлийн зардал өссөнөөс шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Булган мээж ОНӨХХК үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр тогтоолоор Булган мээж ОНӨХХК-ий 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 4,924,944.3 мянган төгрөгөөр, нийт зардлыг 6,710,813.3 мянган төгрөгөөр, 1,785,869.0 мянган төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 126,400.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд өөрчлөлт ороогүй, төсөвт өөрчлөлт оруулаагүй байна.

Гүйцэтгэлээр 4,660,639.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 6,069,150.5 мянган төгрөгийн зардал гарган, 1,806,238.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 5,015,143.5 мянган төгрөг болж төлөвлөснөөс 264,305.0 мянган төгрөг буюу 1.8 хувиар тасарсан нь өмнөх оны авлагыг цуглуулсан, тендерын гүйцэтгэгчээр ажилласнаас голлон нөлөөлсөн байна.

ТУЗ-ийн 2021 оны 04 дүгээр тогтоолоор тайлант онд алдагдалтай төсөв баталсан тул орон нутгийн төсөв ногдол ашиг төвлөрүүлээгүй.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны тайлан мэдээлээгүй, 6 мэдээлэл хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,196,050.90 мянган төгрөгийн орлогын 181 гүйлгээ, зарлагын 146 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.3.1, 6.3.2, 6.3.3, 6.4.4, 6.4.5, 6.4.8-д заасантай тус тус нийцэхгүй байгаад зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- Компанийн гүйцэтгэх удирдлагыг аймгийн Засаг даргын 2020 оны Б/85 дугаар захирамжаар шинэчлэн томилсон, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг аймгийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар тогтоолоор шинэчилж томилсон нь төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2, Компанийн тухай 75 дугаар зүйлийн 75.3 “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтооно”-д заасантай нийцэж байна.
- Булган мээж ОНӨХХК-ий Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 7,200.0 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,512.4 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 93,801.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 23,286.2 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсний биелэлтийг 95.0 хувь гэж дүгнэлээ.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	1,512.4	3	1,512.4	-	-	100.0
Албан шаардлага	2	93,801.3	1	79,801.3	1	14,000.0	85.1
Зөвлөмж	5	23,286.2	5	23,286.2	-	-	100.0
Нийт дүн	10	118,599.9	9	104,599.9	1	14,000.0	95.0

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр Булган аймгийн төвд баригдсан 3000 м3/хоногийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламж барьж байгуулсан "Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл"-ийн зээлийн төлбөр 6,696.6 сая төгрөгийг 2025-2038 оныг дуустал тус тус төлөх хуваарьтай байна. Компаний санхүүгийн чадавхтай уялдуулан урт хугацаат өр төлбөрийг эргэн төлөх гэрээг Булган аймгийн ЗДТГ-тай байгуулаагүй байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8,779,238.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8,126,116.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 653,121.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 262,315.9 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 467,718.1 мянган төгрөгийн түвшнээс 205,402.2 мянган төгрөгөөс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой залруулах алдаагүй гаргаагүй болно.

8.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайланд төлбөрийн акт тогтоогоогүй болно.

8.3 Албан шаардлага

1. ТУЗ-ийн 2021 оны 11-р сарын 17-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор нас барсан иргэний 2019-2021 оны халаалт, цэвэр бохир усны төлбөрийг хариуцах эзэнгүй болсон үндэслэлээр найдваргүй авлагын зардлаар бүртгэсэн, Зардлыг буруу ангилж, санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрдөж ажиллаагүй, дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд зардлыг хуримтлуулан өртгийг хуримтлуулж бүртгээгүй, Бүртгэл тайланд тусгасан авлагын 45 байгууллагын 465.8 сая төгрөгийн үлдэгдлийг тооцооны үлдэгдлээр баталгаажаагүй, БМ-ын тайлангийн 9 дансны үлдэгдэлд өмнөх онуудад бэлтгэсэн 366 нэр төрлийн 164.7 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө, дуусаагүй үйлдвэрлэл дансанд Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр Булган аймгийн төвд баригдсан 3000 м3/хоногийн хүчин чадалтай 6,696.6 тэрбум төгрөгийн цэвэрлэх байгууламжийн барилга бүртгэлтэй, Үндсэн хөрөнгө болон бараа материалын дансны үлдэгдэлд хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоо бодсон акт үйлдээгүй, Үндсэн хөрөнгийн тайлангийн барилга байгууламж дансны үлдэгдэлд 10 нэр төрлийн хөрөнгө бүртгэсэн байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 6 дугаар зүйлийн 6.1, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасантай тус тус нийцэхгүй байна.

2. Эргэлтийн хөрөнгөд нийт 445,766.20 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа худалдан авалт хийснээс “Загзага хангай” ХХК-аас 46,932.0 мянган төгрөгийн цемент, сан техникийн материал, “Солосейф” ХХК-аас 32,372.80 мянган төгрөгийн ажлын хувцас бэлтгэсэн, ТУЗ-ын зөвшөөрөлгүйгээр 4.5 сая төгрөгийн гэр худалдан авсан, ТУЗ-ийн гишүүдэд хоол, шатахуун, томилолт, сургалтын зардал, ТУЗ 2021 оны 01 дүгээр тогтоолоор “Булган мээж” ХХК-ийн 2017-2020 оны санхүүгийн тайланг 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн дотор Аудитын байгууллага сонгох эрх олгосон шийдвэр гаргасан, мөн ТУЗ-ийн эрх олгосон тогтоолд аудитыг хийх байгууллагыг сонгон шалгаруулж, ТУЗ-д танилцуулахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосон байхад шууд гэрээ байгуулан “Партер мидланд аудит” ХХК-аар дүгнэлт гаргуулсан, Гүйцэтгэх захирлын нэр дээр бүртгэлтэй утасны дугаарын ярианы төлбөрийг шуудан холбооны зардлаас төлсөн, Түншлэлийн зардал, шагнал урамшуулал, 90 жилийн ойн арга хэмжээний зардалд тус тус гүйцэтгэх захирлын тушаалаар хөрөнгө зарцуулсан, Дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны тайлан мэдээлээгүй, 6 мэдээлэл хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,196,050.90 мянган төгрөгийн орлогын 181 гүйлгээ, зарлагын 146 гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3, 1.4, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.3.1, 6.3.2, 6.3.3, 6.4.4, 6.4.5, 6.4.8-д заасантай тус тус нийцэхгүй байна.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь стандартад нийцээгүй байна. Энэ нь Нягтлан бодох 18 дугаар зүйлийн 18.1. "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ",

18.2 "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" -д заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын үйл ажиллагаанд нийцсэн байхаар боловсруулж мөрдөх.

2. Компаний засаглалтай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар тогтоолоор ТУЗ-д томилогдсон 7 гишүүнээс Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах эрхийн сертификатгүй 5 гишүүн байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 30, 67 дугаар тогтоолоор батлагдсан "Булган мээж" ОНӨХХК-ийн дүрмийн 5.3 дахь заалтын хэрэгжилтийг хангуулж, 5.2-т заасан гуравны нэг нь хараат бус байх заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

Илрүүлэлт 2: Төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогчийн үүргийг мөргөшсөн нягтлан бодогч хүнээр гүйцэтгүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Илрүүлэлт 3: Урт хугацаат өр төлбөр дансанд Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр "Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл"-ийн хүрээнд Булган аймгийн төвд 3000м3/хоногийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр дамжуулан зээлдүүлэх гэрээний төлбөр бүртгэлтэй байна.

Өгсөн зөвлөмж: Дамжуулан зээлдүүлэх гэрээнд гарын үсэг зурсан хуулийн этгээдтэй, зээлийн эргэн төлөлтийн талаар гэрээ байгуулан, урт хугацаат өр төлбөрийг бууруулах арга хэмжээг зохион байгуулан ажиллах.

Илрүүлэлт 4: Хоёр удаагийн Шүүхийн шийдвэрээр халуун усны түрээслэгч Амгаланбаатараас үүссэн авлагын үлдэгдэлтэй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох шүүхийн шийдвэрийг ШШГА-аар гүйцэтгэх ажиллагааг хийлгүүлж, авлагыг бууруулах ажил зохион байгуулан, алдагдлыг бууруулахад анхаарч ажиллах.

3. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Ажилчин албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг тайлант хугацаанд шинэчилж баталгаажуулаагүй, тайлант онд шинээр нэмэгдсэн хөрөнгийг бүрэн коджуулаагүй, эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл батлагдсан маягтаар хийгдээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан, тооллогыг чанартай хийж байх, данс тус бүрийн тооцоо бодож баталгаажуулж хэвших.

Илрүүлэлт 2: Үлдэх өртөггүй 68 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь НББОУС-16 "Үндсэн хөрөнгө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" –д заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Стандартыг хангуулж ажиллах тал дээр арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Булган мээж ХХК	БУА-2022/02-НА-СТА-ОНӨААН	ТУЗ-ийн 2021 оны 11-р сарын 17-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор нас барсан иргэний 2019-2021 оны халаалт, цэвэр бохир усны төлбөрийг хариуцах эзэнгүй болсон үндэслэлээр найдваргүй авлагын зардлаар бүртгэсэн, Зардлыг буруу ангилж, санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрдөж ажиллаагүй, дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд зардлыг хуримтлуулан өртгийг хуримтлуулж бүртгээгүй, Бүртгэл тайланд тусгасан авлагын 45 байгууллагын 465.8 сая төгрөгийн үлдэгдлийг тооцооны үлдэгдэлээр баталгаажаагүй, Бараа материалын тайлангийн 9 дансны үлдэгдэлд өмнөх онуудад бэлтгэсэн 366 нэр төрлийн 164.7 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө, дуусаагүй үйлдвэрлэл дансанд Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр Булган аймгийн төвд баригдсан 3000 м3/хоногийн хүчин чадалтай 6,696.6 тэрбум төгрөгийн цэвэрлэх байгууламжийн барилга бүртгэлтэй, Үндсэн хөрөнгө болон бараа материалын дансны үлдэгдэлд хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоо бодсон акт үйлдээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй, Үндсэн хөрөнгийн тайлангийн барилга байгууламж дансны үлдэгдэлд 10 нэр төрлийн хөрөнгө бүртгэсэн байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 6 дугаар зүйлийн 6.1, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасантай тус тус нийцэхгүй байна.	1	7,631,219.10							1	7,631,219.10		

2		Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь стандартад нийцээгүй байна. Энэ нь Нягтлан бодох 18 дугаар зүйлийн 18.1."нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2 "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" -д заасныг хэрэгжүүлээгүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын үйл ажиллагаанд нийцсэн байхаар боловсруулж мөрдөх.	1	0									1	0
3		Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар тогтоолоор ТУЗ-д томилогдсон 7 гишүүнээс Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах эрхийн сертификатгүй 5 гишүүн байна.	Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 30, 67 дугаар тогтоолоор батлагдсан "Булган мээж" ОНӨХХК-ийн дүрмийн 5.3 дахь заалтын хэрэгжилтийг хангуулж, 5.2-т заасан гуравны нэг нь хараат бус байх заалтыг хэрэгжүүлэн ажиллах.	1	0									1	0
4		Төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогчийн үүргийг мэргэшсэн нягтлан бодогч хүнээр гүйцэтгүүлээгүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.	1	0									1	0
5		Урт хугацаат өр төлбөр дансанд Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр "Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл"-ийн хүрээнд Булган аймгийн төвд 3000м3/хоногийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр дамжуулан зээлдүүлэх гэрээний төлбөр бүртгэлтэй байна.	Дамжуулан зээлдүүлэх гэрээнд гарын үсэг зурсан хуулийн этгээдтэй, зээлийн эргэн төлөлтийн талаар гэрээ байгуулан, урт хугацаат өр төлбөрийг бууруулах арга хэмжээг зохион байгуулан ажиллах.	1	0									1	0

6		Хоёр удаагийн Шүүхийн шийдвэрээр халуун усны түрээслэгч Амгаланбаатараас үүссэн авлагын үлдэгдэлтэй байна.	Холбогдох шүүхийн шийдвэрийг ШШГА-аар гүйцэтгэх ажиллагааг хийлгүүлж, авлагыг бууруулах ажил зохион байгуулан, алдагдлыг бууруулахад анхаарч ажиллах.	1	18190.4									1	18190.4
7		Ажилчин албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг тайлант хугацаанд шинэчилж баталгаажуулаагүй, тайлант онд шинээр нэмэгдсэн хөрөнгийг бүрэн коджуулаагүй, эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл батлагдсан маягтаар хийгдээгүй байна.	Бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан, тооллогыг чанартай хийж байх, данс тус бүрийн тооцоо бодож баталгаажуулж хэвших.	1	0									1	0
8		Үлдэх өртөггүй 68 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь НББОУС-16 "Үндсэн хөрөнгө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" –д заасныг хэрэгжүүлээгүй байна.	Стандартыг хангуулж ажиллах тал дээр арга хэмжээ авч ажиллах.	1	634930.9									1	634930.9
				8	8,284,340.40	0	0	0	0	1	7,631,219.10	0	0	7	653,121.30

Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал

Булган мээж ХХК	БУА-2022/02-НА-СТА-ОНӨААН	Эргэлтийн хөрөнгөд нийт 445,766.20 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа худалдан авалт хийснээс "Загзага хангай" ХХК-аас 46,932.0 мянган төгрөгийн цемент, сан техникийн материал, "Солосейф" ХХК-аас 32,372.80 мянган төгрөгийн ажлын хувцас бэлтгэсэн, ТУЗ-ын зөвшөөрөлгүйгээр 4.5 сая төгрөгийн гэр худалдан авсан, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд хоол, шатахуун, томилолт, сургалтын зардал, ТУЗ 2021 оны 01 дүгээр тогтоолоор "Булган мээж" ХХК-ийн 2017-2020 оны санхүүгийн тайланг 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн дотор Аудитын байгууллага сонгох эрх олгосон шийдвэр гаргасан, мөн ТУЗ-ийн эрх олгосон тогтоолд аудитыг хийх байгууллагыг сонгон шалгаруулж, ТУЗ-д танилцуулахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосон байхад шууд гэрээ байгуулан "Партер мидланд аудит" ХХК-аар дүгнэлт гаргуулсан, Гүйцэтгэх захирлын нэр дээр бүртгэлтэй утасны дугаарын ярианы төлбөрийг шуудан холбооны зардлаас төлсөн, Түншлэлийн зардал, шагнал урамшуулал, 90 жилийн ойн арга хэмжээний зардалд тус тус гүйцэтгэх захирлын тушаалаар хөрөнгө зарцуулсан, Дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны тайлан мэдээлээгүй, 6 мэдээлэл хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,196,050.90 мянган төгрөгийн орлогын 181 гүйлгээ, зарлагын 146 гүйлгээг мэдээлээгүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 1.4-д "Үнэн зөв байх", 1.5-д "Хэмжигдэхүйц байх", 6.1-д "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"-д заасантай тус тус нийцэхгүй байна.	1	494,897.60					1	494,897.60				
		ДҮН		1	494,897.60	-	-	-	-	1	494,897.60	-	-	-	-
		НИЙТ ДҮН		9	8,779,238.00	-	-	-	-	2	8,126,116.70	-	-	7	653,121.30